

Golomt Capital®

Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.07.04

Олон улсын
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ОНЦЛОХ ИНДЕКСҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ


Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$31,097.26	\$31,500.68	-1.28%	\$32,899.70	-5.48%	\$34,786.35	-10.60%
S&P 500	\$3,825.33	\$3,911.74	-2.21%	\$4,108.54	-6.89%	\$4,352.34	-12.11%
Nasdaq	\$11,127.84	\$11,607.62	-4.13%	\$12,012.73	-7.37%	\$14,639.33	-23.99%

Европийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 12,813.03	€ 13,118.13	-2.33%	€ 14,460.09	-11.39%	€ 15,650.09	-18.13%
FTSE 100	£7,168.65	£7,249.77	-1.12%	£7,610.77	-5.81%	£7,125.20	0.61%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,466.72	¥4,394.77	1.64%	¥4,089.57	9.22%	¥5,085.79	-12.17%
Hang Seng	HKD 21,859.79	HKD 21,719.06	0.65%	HKD 21,082.13	3.69%	HKD 28,310.42	-22.79%
Nikkei 225	JPY 25,935.62	JPY 26,491.97	-2.10%	JPY 27,761.57	-6.58%	JPY 28,783.28	-9.89%

Индексийн өөрчлөлт



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИГЛАХ ТАВАН ЗҮЙЛС

1. АНУ-ын ажил эрхлэлтийн мэдээлэл

Хөрөнгө оруулагчид хөдөлмөрийн зах зээл хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг энэ долоо хоногт зарлагдах эдийн засгийн үзүүлэлтээс харах боломжтой. Эдийн засагчид 270,000 ажлын байр өнгөрсөн зургаан сард нэмэгдсэн гэсэн хүлээлттэй байгаа ба энэ нь өмнөх сарын 390,000-аас 30 хувиар бага байна.

Харин ажилгүйдлийн түвшин 3.6 хувь хэвээр байна гэсэн хүлээлттэй байгаа нь эдийн засаг удааширсан ч эрэлт тогтвортой байгааг илтгэнэ.

Шинжээчид дундаж нэг цагийн орлогыг жилийн өмнөхөөс ойролцоогоор 5 хувиар өснө гэсэн таамаглалтай байна.

2. Холбооны нөөцийн сангийн хурлын тэмдэглэл

ХНС энэ сард бодлогын хүүгээ 75 нэгжээр өсгөх хүлээлттэй байгаа ч есөн сард бодлогын хүүг хэдэн нэгжээр өсгөх нь тодорхойгүй байна.

Энэ лхагва гарагт ХНС-гийн зургаа дугаар сарын уулзалтын хурлын тэмдэглэл зарлагдах ба энэ нь хөрөнгө оруулагчдад ирээдүйн бодлогын хүү болон мөнгөний бодлогын талаар бага зэргийн таамаглал өгөх болно.

Харин Европын төв банк энэ пүрэв гарагт зургаа дугаар сарын хурлын тэмдэглэл зарлагдах болно.

3. АНУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд

АНУ лхагва гарагт 5-р шинэ ажлын байрны талаарх тоон мэдээллийг нийтэлнэ. 4-р сард 11.4 сая шинэ ажлын байр бий болсон бол 5 сард 11 саяд хүрэх төлөвтэй байна. Ажлын байрыг хангахуйц чадвартай ажилтан дутмаг байгаагийн улмаас дундаж цалин өсөлттэй байна.

Мөн өмнөх сарын үйлдвэрлэлийн бус PMI индекс, үйлдвэрийн захиалга, анхны ажилгүйдлийн тэтгэмж авах хүмүүсийн тоо, хэрэглэгчийн кредит зэрэг тоон мэдээллүүдийг зарлана.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

4. Тайлангийн хур бууна

Уолл Стритийн гурван томоохон хувьцааны индекс баасан гарагт өсөлттэй долоо хоногийг өндөрлөсөн.

Энэ сард болох хэд хэдэн томоохон үйл явц нь хөрөнгийн зах зээлийн уналт болон өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох болно.

7-р сарын 11-ээс компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлан зарлагдах ба энэ нь эдүгээ хэрэгжүүлж буй мөнгөний бодлого нь компаниудад хэрхэн нөлөөлж байгааг харуулах болно.

5. Австралийн төв банкны бодлогын хүүгийн өсөлт


















Австралийн төв банк энэ мягмар гарагт бодлогын хүүгээ дахин 50 нэгжээр өсгөх төлөвлөгөөтэй байна.

Өнгөрсөн сард шинжээчид бодлогын хүүг 25 нэгжээр өсгөнө гэж таамаглаж байсан бол амбан захирагч Филип Лоуг 50 нэгжээр нэмэгдүүлсэн. Тэгвэл энэ удаад мөн адил 50 нэгжээр бодлогын хүүг өсгөнө гэж шинжээчид таамаглаж байна.

Долларын эсрэг Австралийн мөнгөн тэмдэгт суларсан нь инфляцыг өдөөхийн зэрэгцээ эрчим хүч, хөдөлмөрийн зардлыг нэмэгдүүлж байна. ОХУ-ын Украин дахь дайн, Австралийн худалдааны хамгийн том түнш болох Хятадад өрнөж буй ковидын нөхцөл байдал инфляцыг улам бүр дордуулж байна.

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning June 27, 2022				
Monday		Tuesday		Wednesday		Thursday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
						
						
						
						
						
						
						
						
						
http://eps.sh/cal		© 2022 Earnings Whispers				

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning July 04, 2022				
Monday		Tuesday		Wednesday		Thursday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
						
						
						
http://eps.sh/cal		© 2022 Earnings Whispers				

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.